

ГАДААДЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛ ХЯНАЛТЫН ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ

*Г.Баярмагнай**

Гадаадын иргэний эрх зүй байдлын тухай хуульд 2000 оны 12 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар оруулсан нэмэлт, өөрчлөлтөд заасны дагуу Засгийн газар 2001 оны 4 дүгээр сард тогтоол гаргаж, тус албыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх ажлын хүрээнд байгуулсан нь гадаадын иргэн, харьяат, цагаачлалын талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Тус албаны үндсэн үйл ажиллагаа нь тус улсад орох, гарах, оршин суух, цагаачлах гадаадын иргэн, харьяалалгүй хүнд зөвшөөрөл, виз олгох, бүртгэж хянах, гадаадад цагаачлах өөрийн иргэдэд зөвшөөрөл олгох, иргэний харьяаллын асуудлаар гарсан хүсэлтийг хянаж Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулж Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж шийдвэр гаргуулах, тус улсад төлөөлөгчийн газар нээн ажиллуулах тухай гадаадын төрийн бус байгууллагын болон Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авах тухай гадаадын иргэдийн хүсэлтийг хянаж шийдвэрлэх явдал юм.

Мөн гадаадын иргэн, харьяат, цагаачлалын талаар төрийн бодлого боловсруулахад санал өгөх, хүн амын тоо, нягтрал, газар зүйн байршил, хөгжлийн түвшин зэрэг хүчин зүйлтэй уялдуулан тус улсад цагаачлах гадаадын иргэдийн тоо, бүтэц, хөдөлгөөний талаар санал боловсруулах, дээрх үндсэн гурван чиглэлээр төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, энэ талаархи төрийн бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, тодорхой асуудлаар үүрэг, даалгавар өгч биелэлтийг хангуулах, тус улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудыг гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан холбогдох мэдээлэл, мэргэжил-арга зүйн удирдлагаар хангах үйл ажиллагаа явуулдаг.

Тус алба Засгийн газрын 168 дугаар тогтоолоор “Гадаадын иргэнийг бүртгэх, гадаадын иргэн Монгол Улсад түр болон удаан хугацаагаар оршин суух, байнга оршин суух, цагаачлах журам”-ыг батлуулан мөрдөж эхэлсэн нь тус албаны өдөр тутмын үйлчилгээний ажлын хэм хэмжээг тогтоож өгсөн маш чухал ач холбогдолтой алхам

*Г.Баярмагнай - Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны дэд дарга

болсон бөгөөд энэ журмын дагуу бүртгэл, зөвшөөрлийн үйл ажиллагааг явуулж байна.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар тус улсад хувийн хэргээр удаан хугацаагаар болон байнга оршин суугч, цагаач гадаадын иргэдийн тоо манай хүн амын 1 хүртэл хувийг эзэлж болох, үүний дотор нэг улсын иргэн 0.33 хүртэл хувь байж болохыг тогтоож өгсөн.

УИХ-аас 2000-2004 онд тус улсад оруулж болох цагаач иргэдийн тоог нэг мөр тогтоож өгсөн. Уг тогтоолд зааснаар, дурдсан хугацаанд жил бүр 100 хүртэл гадаадын цагаачийг оруулж болох, түүний дотор ОХУ, БНХАУ-ын цагаач тус бүр 30-аас хэтрэхгүй байх ёстой.

Эдүгээ Монгол Улсад гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын төлөөлөгчийн газар, хэвлэл, мэдээллийн төлөөлөгчийн газарт ажиллагсад, тэдний гэр бүлийн гишүүдийн бүртгэлийг ГХЯ эрхлэн явуулдаг. Мөн төрийн захиргаа болон нутгийн өөрөө удирдах байгууллагын урилгаар ирэх гадаадын зочид, зорчигч /30 хоногийн хугацаагаар ирсэн гадаадын иргэн/-ийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд 2001 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр бүртгэхээ больсон.

Үүнээс бусад 2003 оны эцсийн байдлаар Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа тус албанд бүртгэлтэй гадаадын иргэн 15036 байна. Үүнээс:

- Түр хугацаагаар оршин суугч 1260
- Хувийн хэргээр удаан хугацаагаар 146
- Албан хэргээр удаан хугацаагаар 10460
- Байнга оршин суугч 912
- Цагаач 2258
- Харьяалалгүй хүн 82

Тус алба холбогдох хууль тогтоомжийн дагуу гадаадын иргэнийг ирсэн зорилго, үйл ажиллагаа байдлаар нь хэд хэд ангилан бүртгэл, хяналтын үйл ажиллагаа явуулж байна.

1. Түр оршин суугч гэдэг нь Монгол Улсад хувийн хэргээр 31-ээс 90 хүртэл хоногийн хугацаагаар байгаа гадаадын иргэнийг хэлдэг бөгөөд энэ тоо өдөр бүр хэлбэлзэж байдаг. Өнөөдрийн байдлаар тус албанд бүртгэлтэй 45 орны 1260 түр ирэгч гадаадын иргэн байна

2. Албан хэргээр удаан хугацаагаар оршин суугч гэж Монгол Улсад засгийн газар хоорондын гэрээгээр суралцах, ажил, албан тушаал эрхлэх, гадаадын төрийн бус болон олон улсын байгууллагын

төлөөлөгчийн газар, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн удирдах бүрэлдэхүүнд ажиллах болон тэдэнтэй адилтгах албан тушаал эрхлэн 90 хоногоос дээш хугацаагаар оршин суух гадаадын иргэн юм. Тус албанд бүртгэлтэй 10460 байна.

Үүнээс БНХАУ-ын 3760 иргэн байгаагаас 815 нь гадаадын хөрөнгө оруулагч, 2615 нь хувиар хөдөлмөр /бизнес/ эрхлэгч, 184 нь оюутан, бусад 146 нь тэдгээрийн гэр бүлийн хүмүүс байна.

ОХУ-ын 2700 иргэд байгаагаас 72 нь гадаадын хөрөнгө оруулагч, 1549 нь хөдөлмөр эрхлэгч, 220 нь оюутан, бусад 859 нь тэдгээрийн гэр бүлийн гишүүд байна.

3. Хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугч гэж Монгол Улсад хувийн хэргээр 90 хоногоос 5 жил хүртэл хугацаагаар оршин суугаа гадаадын иргэнийг хэлдэг. Одоогийн байдлаар Монгол Улсад нийт 21 орны 146 иргэн байна. Үүнээс нийслэлд 133, бусад 13 нь Орхон аймагт 5, Баян-Өлгий, Сэлэнгэ аймагт тус тус 3, Булган аймагт 1 иргэн оршин сууж байна. Үүнээс БНХАУ-ын 12, ОХУ-ын 20 иргэн байна.

Хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугчдын тоо сүүлийн жилүүдэд хэлбэлзэж ирсэн боловч 150-иас хэтэрч байгаагүй юм. Тухайлбал алба байгуулагдаж байх үе 2001 онд 43 байсан бол 2002 онд 30 болж 29.3 хувиар буурснаа эдүгээ 37.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

4. Байнга оршин суугч гэж Монгол Улсын харьяат иргэнтэй гэр бүл болсон, 90 хоногоос дээш хугацаагаар Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэнийг хэлдэг бөгөөд өнөөдрийн байдлаар тус албанд бүртгэлтэй 924 гадаадын иргэн байна. Сүүлийн жилүүдэд байнга оршин суугчдын тоо өссөөр байна. Энэ нь гадаад иргэд манай иргэдтэй гэр бүл болох явдал өсч байгаатай холбоотой. Гэр бүл болох явдал 2001 онд 196, 2002 онд 315, 2003 онд 526 болж өссөн үзүүлэлттэй байна. Иймээс байнга оршин суугчдын тоо 2001 онд 588 байсан бол 2002 онд 609 болж 4.0 хувиар 2003 онд 912 болж 27.0 хувиар тус тус өссөн байна.

Нийт байнга оршин суугчын дотор БНХАУ-ын 227 иргэн байна. Байршлаар нь авч үзвэл, нийслэлд 194, Сэлэнгэд 16, Дарханд 8, Дорнодод 5, Ховдод 2, Орхон, Баян-Өлгийд тус тус 1 иргэн оршин сууж байна.

Мөн нийт байнга оршин суугчын дотор ОХУ-ын 413 иргэн байна. Үүнээс нийслэлд 330, Сэлэнгэд 27, Орхонд 23, Дарханд 17, Дорнодод 10, Баян-Өлгий, Хэнтийд тус тус 2, Булган, Өмнөговьд тус тус 1 байна.

5. Цагаач гэж хувийн хэргээр Монгол Улсад амьдрахаар 5 жилээс дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэнийг хэлнэ.

Цагаач иргэдийн тоо сүүлийн 2 жилд буурсан статистик үзүүлэлттэй байгаа. Гэвч бодит байдал дээр тийм биш юм. Учир нь тус алба зохих шаардлагыг хангасан гадаадын иргэдэд хүсэлтийнх нь дагуу тус улсад цагаачлах зөвшөөрөл олгож ирсэн. Тухайлбал, 2001 онд 5 орны 34 хүнд, 2002 онд 6 улсын 26 хүнд, 2003 онд 8 орны 22 хүнд нийт 82 гадаадын иргэнд цагаачлах зөвшөөрөл олгосон байна. Тус алба байгуулагдаж байх үед 3000 гаруй цагаач гадаадын иргэн байгаа гэсэн тоо байсан боловч хувийн хэрэгтэй нь нягтлан танилцаж, нутаг буцсан, нас барсан, харьяаллаа өөрчлүүлсэн хэсгийг ялгаж үзэхэд зөрөө гарсан. Үүний шалтгаан нь гол төлөв ЗСБНХУ-ын /хуучин нэрээр/ иргэн цагаачдыг байнга оршин суугчидтай хольж бүртгэл тооцоо гаргаж байсантай холбоотой байсныг бид илрүүлэн засаж залруулах арга хэмжээ авсаар байна. Энэ нь холбогдох хуулийн заалт бүрэн хэрэгжиж, түүнчлэн тус улсад цагаачилж буй гадаадын иргэдийн талаар ойрын үед зохицуулахад төвөгтэй асуудал гарахааргүй байгааг харуулж байна.

Одоо тус улсад 13 орны нийт 2258 хүн цагаачлан амьдарч байна. Үүнээс 1323 БНХАУ-ын, 888 ОХУ-ын, 47 нь бусад 11 орны цагаач оршин сууж байна.

Харьяатын асуудлаар

Гадаадын иргэн, харьяалалгүй хүнээс Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргаж, Монгол Улсын харьяат болсон нийт 5 орны 214 хүн байна. Үүнээс БНХАУ 157, ОХУ 51, БНКаз 4, БНСУ, Балбын тус тус 1 хүн байна. Эдгээр хүмүүсийн харьяат болох асуудлыг 1980.07.17-2001.03.30-ны хооронд шийдвэрлэсэн байна.

Харьяатын тухай хуульд 2000 оны 12 дугаар сард нэмэлт, өөрчлөлт орж, энэ нэмэлтийн дагуу харьяат болох асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагаа түр хойшлогдож байсан.

Дээрхи хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу 2003 онд Засгийн газрын 62 дугаар тогтоолоор “Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүн хуульд заасан шалгуурыг хангасан эсэхийг тогтоох журам”-ыг баталсан. Энэ журмаар Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргагчид ямар шалгуур үзүүлэлтийг хангах, түүнийг тус алба хэрхэн шалгаж тогтоохыг зохицуулсан. Мөн ямар тохиолдолд тухайн гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүсэлтийг хуульд заасан шалгуурт хамааруулахгүйгээр шууд Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж болохыг зааж өгсөн.

Одоогийн байдлаар Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан 21 хүний материалыг тус алба дээр дурдсан журмын дагуу хянан шалгаж байна. Үүнээс харьяат болох 8 хүний /үүний 7 нь хятад гаралтай харьяалалгүй хүний, 1 нь орос гаралтай харьяалалгүй хүний/ материалыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн бариад байна. Бусад 13 хүний материалыг хянаж, холбогдох газрын саналыг авах зэрэг бүрдлийн ажиллагааг явуулж байна.

Захиргааны арга хэмжээ авагдсан байдал

Монгол Улсад оршин суух, хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг хуурамчаар үйлдсэн, нийгмийн хэв журам удаа дараа зөрчсөн, хууль бусаар удаан хугацаагаар оршин суусан зэрэг зөрчил гаргасан гадаадын 8 орны 190 иргэнийг Албаны даргын тушаалаар Монгол Улсаас захиргааны журмаар гаргаж, Монгол Улсын хилээр 1-3 жилийн хугацаатайгаар үл нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн болно. Эдгээр 190 гадаадын иргэний 159 буюу 83.6% нь БНХАУ, 18 буюу 9.2% нь Пакистан, 13 буюу 7.2% нь бусад 6 орны /ОХУ-1/ иргэд байна.

Мөн 2003 онд Монгол Улсад оршин суух, дамжин өнгөрөх, бүртгэл, хөдөлмөр эрхлэх талаар тогтоосон журам зөрчсөн болон визийн хугацаа хэтэрсэн, оршин суух үнэмлэх үрэгдүүлсэн зэргээс 52 орны 1732 иргэнд Захиргааны хариуцлагын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу 191 сая 360 мян. төгрөгийн торгууль ногдуулсан байна. Улс орноор нь авч үзвэл 1732 гадаадын иргэний 1224 буюу 70.6% нь БНХАУ-ын иргэд, 132 буюу 7.6% нь ОХУ-ын иргэд, 376 буюу 21.8% нь бусад 50 орны иргэд байна.

Гэмт хэрэгт холбогдсон болон шүүхээр шийтгүүлсэн байдал

Гадаадын иргэд гэмт хэрэгт холбогдох явдал гарсаар байгаа боловч сүүлийн 3 жилийн байдлаар буурсан үзүүлэлт гарсан. Тухайлбал Цагдаагийн Ерөнхий газраас ирүүлсэн мэдээгээр 2001 онд нийт 63 байснаас БНХАУ 31, ОХУ 24, АНУ, БНСУ, Пакистан тус тус 2, Унгар 1 иргэн байсан. 2002 онд нийт 40 гадаадын иргэн гэмт хэрэгт холбогдож байсан байна. Үүнээс БНХАУ 15, ОХУ 15, БНСУ 9, ХБНГУ 1 иргэн байсан. Харин 2003 онд 4 орны 37 иргэн гэмт хэрэгт холбогдсоноос БНХАУ 30, ОХУ 5, Вьетнам, ХБНГУ тус тус 1 иргэн байна.

Гэмт хэрэгт холбогдон шалгагдаж шүүхээр шийтгүүлэн хорих ял эдэлсэн гадаадын иргэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээгээр 2001 онд 2 орны 25, үүний 21 нь ОХУ-ын, 4 нь БНХАУ-ын иргэн байсан. 2002 онд 3 орны 10 иргэний 7 нь ОХУ, 2 нь БНСУ, 1 нь БНХАУ-ын иргэн байв. Харин 2003 он буюу одоогийн байдлаар 3 орны 14 байгаагийн 8 нь ОХУ-ын, 3 нь БНСУ-ын, 3 нь БНХАУ-ын иргэд байна.